



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ

13335 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Нам Ян Жулийн гудамж 3211, Утас: 45 39 94,
Факс: (976-11) 45 86 99, E-mail: info@ncod.gov.mn,
<http://www.ncod.gov.mn>

2016 - 09 - 21 № 7/1102
танай _____ -ны № _____ -т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР,
БОЛОВСРОЛЫН ГАЗАРТ

Зөвлөмж хүргүүлэх тухай

Улсын хэмжээнд томуу төст өвчний амбулаторийн үзлэгт эзлэх хувь сүүлийн долоо хоногуудад аажмаар нэмэгдэж, ХӨСҮТ-ийн Вирус судлалын лаборатори, бүсийн салбар лабораториудад хийгдэж буй өвчтөнөөс авсан хамар залгиурын сорьцонд риновирус давамгайлан тодорхойлогдож байна.

Риновирус нь хамрын ханиад, шуухинааны голлох шалтгаан болдог бөгөөд жилийн дөрвөн улиралд эргэлтэнд байж, намар хүйтэн сэрүүний улирал (8-9 сар)-д дэгдэлт хэлбэрээр тархан, бүх насныхан халдварт өртөх эрсдэлтэй. Риновирусын халдварын үед хоолой өвдөх, нус гоожих, хамар битүүрэх, ханиах, найтаах зэрэг эмнэлзүйн шинж тэмдэг илрэх ба булчин өвдөх, ядрах, сульдах, толгой хүчтэй өвдөх, хоолонд дургүй болох, халуурах зэрэг томуу төст эмнэлзүйн шинж илэрдэг. Сургууль, цэцэрлэгийн цугларалт, хүмүүсийн хөл хөдөлгөөн, нягтрал нэмэгдэх нь амьсгалын замын халдвар хүнээс хүнд хурдан тархах нөхцлийг бүрдүүлдэг билээ.

Томуу төст өвчний 70-80 хүртэлх хувийг сургууль, цэцэрлэгийн насны хүүхдийн өвчлөл эзэлж байгаа тул урьдчилан сэргийлэх зорилгоор доорх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагын удирдлага, эмч, багш нарт зөвлөмж болгож байна. Үүнд:

1. Сургууль, цэцэрлэгт хүүхдийг хүлээн авахдаа биеийн байдлыг нягтлан үзэж, томуу томуу төст өвчин (ТӨ), амьсгалын замын халдварын шинж тэмдэгтэй болон өвчилсөн хүүхэд, өвчилсөн багш, ажилчдыг хичээл, сургуулиас 7 хоног хүртэл чөлөөлж, өвчний хүндрэлээс сэргийлж, гэрт нь тусгаарлах, эмчилж, эдгэрүүлэх;